Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нэлээ бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 961,861.8 мянга, эцсийн үлдэгдэл 828,037.9 мянган төгрөг болж 133,823.8 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|---|
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ ДҮН** | **961,861.8** | **828,037.9** | **-133,823.8** |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **961,861.8** | **828,037.9** | **-133,823.8** |
| **31210** | **Төгрөг** | **961,861.8** | **828,037.9** | **-133,823.8** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 961,861.8 | 828,037.9 | -133,823.8 |

*Эх сурвалж: Өлзийт сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 828,037.9 мянган төгрөг нь төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн 227,584.9 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 183,381.2 мянга, Хоршоо хөгжүүлэх сангийн дансанд 124,246.5 мянга, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 292,825.3 мянган төгрөг байршиж байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 219,689.8 мянга, эцсийн үлдэгдэл 135,648.8 мянган төгрөг болж 84,041.0 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл* *|мянган төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.00 | 0.00 | 0.00 | |
| 33200 | Төлбөрт үйлчилгээний авлага | 7027.2 | 0 | 7027.2 | 0.0% |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | | | 0 | |
| **33510** | **Байгууллагаас авах авлага** | | | 0 | |
| **33520** | **Хувь хүмүүсээс авах авлага** | 3,942.70 | 2,922.70 | 1020 | 74.1% |
| **336** | **Зээлийн авлага** | 208,719.90 | 132,726.10 | 75993.8 | 63.6% |
| | **Дүн** | **219,689.80** | **135,648.80** | **84,041.00** | **61.7%** |

*Эх сурвалж: Өлзийт сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Тайлант онд авлага дансны үлдэгдэл буурсан шалтгаан нь ЗДТГ-ын төлбөрт үйлчилгээний 7,027.2 мянган төгрөгийн авлага барагдсан, ОНХСангийн хувь хүмүүсээс авах 1,020.0 мянган төгрөгийн авлага барагдсан мөн ХХСангийн авлага75,993.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

*Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл /байгууллагаар/* */мянган төгрөгөөр/*

| Д.д | Байгууллагуудын нэр | Авлагын эхний үлдэгдэл | Авлагын эцсийн үлдэгдлийн ДҮН | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Иргэдийн төлөөлөгчдийн хурал | | | | |
| 2 | Засаг даргын тамгын газар | 7,027.2 | | -7,027.2 | - |
| 3 | Орон нутгийн хөгжлийн сан | 3,942.7 | 2,922.7 | 1,020.0 | 2.2% |
| 4 | Хоршоо хөгжүүлэх сан | 208,719.9 | 132,726.1 | 75,993.8 | 97.8% |
| | **НИЙТ ДҮН** | **219,689.8** | **135,648.8** | **84,041.0** | **100%** |

*Эх сурвалж: Өлзийт сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Нийт авлагын 97.8 хувь буюу 132,726.1 мянган төгрөгийг сум хөгжүүлэх сангийн авлага, 2,2 хувь буюу 2922,7 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага байна. Хоршоо хөгжүүлэх сангийн авлага оны эхэнд 208,719.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тус онд 1 иргэнд 16,000.0 мянган төгрөгийн зээл олгож тус сангийн үйл ажиллагааны зардалд 100.0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд 92,084.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулж оны эцэст 132,726.1 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 218,034.2 мянга, эцсийн үлдэгдэл 234,808.2 төгрөг болж, 16,774.0 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл* */ мянган төгрөгөөр/*
*Эх сурвалж: Өлзийт сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 53,955.80 | 86,464.90 | 32,509.10 | 36.8% |
| Бичиг хэргийн материал | 2,490.90 | 3,083.00 | 593.00 | 1.3% |
| Аж ахуйн материал | 21,084.50 | 20,991.60 | (92.90) | 8.9% |
| Бусад хангамжийн материал | 76,754.70 | 108,906.50 | 32,151.80 | 46.4% |
| Мал амьтад | 950.00 | 15,362.30 | 14,402.30 | 6.5% |
| Нөөцийн бараа | 62,798.30 | - | (62,798.30) | 0.0% |
| **Дүн** | **218,034.20** | **234,808.20** | **-16,774.00** | **100.0%** |

Бараа материалын дансны үлдэгдэл 234,808.2 мянган төгрөг болж өмнөх оноос 16,774.0 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС, сум дундын ойн ангиас үнэ төлбөргүй олгосон 37,551.4 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 15,362.3 мянган төгрөгийн мал амьтадыг үнэ төлбөргүй орлого авч үлдэгдлээр тайлагнасан нь голлох нөлөө үзүүлж байна.

*Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл* */мянган төгрөгөөр/*

| Бараа материалын орлого, зарлагын үзүүлэлт | Дүн |
|---|---|
| **2023 оны эхний үлдэгдэл** | **218,034.2** |
| ***Нэмэгдсэн*** | **330,496.2** |
| Худалдан авсан | 212,341.3 |
| Шилжүүлэн авсан | 48,352.5 |
| Бусад | 69,802.4 |
| ***Хасагдсан*** | **313,722.2** |
| Худалдсан, зарцуулсан | 149,850.9 |
| Шилжүүлсэн бүтцийн өөрчлөлтөөр | 80,076.7 |
| Шилжүүлсэн | 66,177.8 |
| Бусад | 17,616.8 |
| **2023 оны эцсийн үлдэгдэл** | **234,808.2** |

*Эх сурвалж: Өлзийт сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Тайлант онд нийт нэмэгдсэн 330,496.2 мянган төгрөгийн бараа материалын 212,341.3 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, Сум дундын ойн ангиас 7,865.0 мянган төгрөгийн өвс тэжээл үнэ бүртгэсэн, 15,362.3 мянган төгрөгийн сайн үүлдэрийн эцэг малыг “Хөдөөгийн хөгжил” төслийн хүрээнд үнэ төлбөргүй олгосон, ОНХСангийн эх үүсвэрээр 68,052.4 мянган төгрөгийн өвс тэжээл, аймгийн өвс тэжээлийн нөөц хөрөнгөөс 16,875.2 мянган төгрөгийн өвс тэжээл, хандиваар 10,000.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалыг үнэ төлбөргүй орлого авсан байна.

Мөн тайлант онд нийт 149,850.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, ЗДТГ-ын нөөцөд бүртгэлтэй байсан 66,177.8 мянган төгрөгийн бараа материалыг Өлзийт сумын Ерөнхий Боловсролын Сургууль руу шилжүүлсэн, байна. 80,076.7 мянга төгрөгийн өвс, тэжээлийн зарцуулалттай холбоотой байна. 17,616.8 мянган төгрөгийн бараа материал акталсан.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 8,243,077.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 443,877.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/
*Эх сурвалж: Өлзийт сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| **БИЕТ ХӨРӨНГӨ** | **7,684,941.60** | **8,128,819.30** | **443,877.70** | **98.61%** |
| Барилга байгууламж, орон сууц | 6,898,944.40 | 7,200,668.10 | 301,723.70 | 87.35% |
| Тээврийн хэрэгсэл | 271,758.80 | 351,490.10 | 79,731.30 | 4.26% |
| Машин тоног төхөөрөмж | 359,892.70 | 422,495.40 | 62,602.70 | 5.13% |
| Тавилга эд хогшил | 145,955.90 | 145,775.90 | -180.00 | 1.77% |
| Дуусаагүй барилга байгууламж | 7,400.00 | 7,400.00 | 0.00 | 0.09% |
| Номын фонд | 989.80 | 989.80 | 0.00 | 0.01% |
| Бусад үндсэн хөрөнгө | | | 0.00 | 0.00% |
| **БИЕТ БУС ХӨРӨНГӨ** | **114,258.00** | **114,258.00** | 0.00 | **1.39%** |
| Программ хангамж | 1,434.00 | 1,434.00 | 0.00 | 0.02% |
| Бусад биет бус хөрөнгө | 112,824.00 | 112,824.00 | 0.00 | 1.37% |
| | **7,799,199.60** | **8,243,077.30** | **443,877.70** | **100.00%** |

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,243,077.3 мянган төгрөг болж 443,877.7 мянган төгрөгөөр өссөн нь барилга байгууламж, тээврийн хэрэгсэл , машин тоног төхөөрөмжийн дансны дүн нэмэгдсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

| Байгууллагуудын нэрс | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Хувь |
|---|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 866,652.7 | 873,666.6 | 7,013.9 | 10.6% |
| Засаг даргын тамгын газар | 6,932,546.9 | 7,369,410.6 | 436,863.7 | 89.4% |
| **Дүн** | **7,799,199.6** | **8,243,077.3** | **443,877.6** | **100%** |

*Эх сурвалж: Өлзийт сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Тайлант онд нэмэгдсэн 486,347.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн 62.5 хувь буюу 304,442.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Үүнд: Барилга байгууламж ЗДТГ-т сумын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 195,601.4 мянга, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 65,122.3 мянга, төсвийн хөрөнгөөр 41,000.0 мянган төгрөг нийт 301,723.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн тээврийн хэрэгсэл улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5,711.3 мянган төгрөгийн өртөг бүхий 2 ширхэг мотоцикл, төсвийн хөрөнгөөр 79,000.0 мянган төгрөг нийт 84,711.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тавилга эд хогшил сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 38,008.0 мянга, төсвийн хөрөнгөөр 61,904.7 мянга нийт 99,912.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн хөрөнгөөр 181,904.7 мянга, улсын төсвийн хөрөнгө оруулалаар 5,711.3 мянга, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 65,122.3 мянга, сумын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 233,609.4 мянга нийт 486,347.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнөөс Баянхонгор аймгийн ИТХ-ийн хурлын хуралдааны 2023.10.11-ны өдрийн "Хөрөнгө акталж, данснаас хасах тухай" 16/49 тоот тогтоолоор 31,149.5 мянган төгрөгийн хөрөнгө акталж, Баянхонгор аймгийн ИТХ-ийн хурлын 2023.10.10-ны өдрийн "Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай" 88 дугаар захирамжаар 11,320.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг Өлзийт сумын ЕБС-д шилжүүлэн өгсөн.

*Хүснэгт 9. Үндсэн хөрөнгө* */мянган төгрөгөөр/*

| | |
|---|---|
| **2023 оны эхний үлдэгдэл** | **7,799,199.6** |
| ***Нэмэгдсэн*** | **486,347.6** |
| Худалдан авсан | 181,904.7 |
| Бусад | 304,442.9 |
| ***Хасагдсан*** | **42,470.0** |
| Акталсан | 31,149.5 |
| Шилжүүлсэн | 11,320.5 |
| **2023 оны эцсийн үлдэгдэл** | **8,423,077.3** |

*Эх сурвалж: Өлзийт сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

### 3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр байхгүй.

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,361,526.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,045,665.4 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо* */мянган төгрөгөөр/*

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 795,997.7 | 795,997.7 | - |
| Өмч: - орон нутгийн | 795,997.7 | 795,997.7 | - |
| **Хуримтлагдсан үр дүн** | 7,079,431.9 | 6,921,921.2 | -157,510.7 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 176,821.8 | 176,821.8 | - |
| | **8,052,251.4** | **7,894,740.7** | **-157,510.7** |

*Эх сурвалж: Өлзийт сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан*

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл үлдэгдэл 7,894,740.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 157,510.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5.11 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2022.12.19-ний өдрийн хуралдааны 13/49 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 526,460.0 мянга, ОНХС-ийн шилжүүлгийг 239,431.7 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 16,000.0 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 594,365.5 мянга, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлогыг 70,000.0 мянга, урд оны үлдэгдлийг 776,036.8 мянга нийт 2,222,294.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.05-ны өдрийн 15/09 дүгээр тодотгосон тогтоолоор татварын орлогыг 474,410.9 мянга, татварын бус орлогыг 70,000.0 мянга, ОНХС-ийн шилжүүлгийг 254,560.6 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 700,579.3 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 55,200.0 мянга, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн орлогыг 70,000.0 мянга, урд оны үлдэгдлийг 953,602.9 мянга нийт 2,578,353.7 мянган төгрөгөөр баталсан байна.

*Хүснэгт 12. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл* */мянган төгрөгөөр/*

| Д/д | Орлогын нэр төрөл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | **Нийт дүн** | **544,410,900.0** | **792,499,916.65** | **248,089,016.7** | **145.6%** |
| | **Сумд төвлөрөх орлогын дүн** | **474,410,900.0** | **629,526,416.7** | **155,115,516.7** | **132.7%** |
| 1 | ИОТХ | 15,000,000.0 | 7,966,817.5 | (7,033,182.5) | 53.1% |
| 2 | хадгаламжийн хүүгийн орлого | 27,900,000.0 | 32,692,715.2 | 4,792,715.2 | 117.2% |
| 3 | ҮХЭХ борлуулсны албан татвар | 4,000,000.0 | 5,700,000.0 | 1,700,000.0 | 142.5% |
| 4 | Бууны татвар | 5,580,000.0 | 2,430,000.0 | (3,150,000.0) | 43.5% |
| 5 | Улсын тэмдэгт | 15,000,000.0 | 25,770,014.0 | 10,770,014.0 | 171.8% |
| 6 | Газрын төлбөр | 10,200,000.0 | 5,468,294.0 | (4,731,706.0) | 53.6% |
| 7 | Ан агнуур | 38,080,000.0 | 196,166,044.0 | 158,086,044.0 | 515.1% |
| 8 | Газрын дуудлага худалдаа | 18,000,000.0 | 13,718,800.0 | (4,281,200.0) | 76.2% |
| 9 | Хог хаягдлын үйлчилгээний төлбөр | 13,500,000.0 | 17,448,700.0 | 3,948,700.0 | 129.2% |
| 10 | ЦХАТ /суутган/ | 169,290,000.0 | 205,799,596.3 | 36,509,596.3 | 121.6% |
| 11 | ҮХЭХ-ийн татвар | 3,300,000.0 | 2,219,821.4 | (1,080,178.6) | 67.3% |
| 12 | Малын тоо толгойн албан татвар | 132,360,900.0 | 95,005,730.0 | (37,355,170.0) | 71.8% |
| 13 | Ус рашаан ашигласны төлбөр | 1,200,000.0 | 1,139,884.3 | (60,115.7) | 95.0% |
| 14 | ТТАМАТөлбөр | 21,000,000.0 | 18,000,000.0 | (3,000,000.0) | 85.7% |
| | **Татварын бус орлого** | **70,000,000.0** | **162,973,500.0** | **92,973,500.0** | **232.8%** |
| 15 | Хүү торгууль | 70,000,000.0 | 162,973,500.0 | 92,973,500.0 | 232.8% |

*Эх сурвалж: Өлзийт сумын ИТХ-ын тогтоол*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 155,115.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн ч орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлогын татвар хураамж 7,033.2 мянга, бууны татвар 3,150.0 мянга, газрын төлбөр 4,731.7 мянга, газрын дуудлага худалдааны орлого 4,281.2 мянга, үл хөдлөх эрхийн хураамжийн татвар 1,080.2 мянга, малын тоо толгойн албан татвар 37,355.2 мянга, ус рашаан ашигласны төлбөр 60.2 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 3,000.0 мянган төгрөгөөр тус тус батласан төлөвлөгөө биелээгүй бөгөөд нийт 8 нэр төрлийн татварын орлогын 60,691.5 мянган төгрөгөөр тасарсан байна.

### 3.5.12 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,578,353.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,117,479.9 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулсан. 1,638,930.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж 478,549.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд буюу ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 6 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн бөгөөд Иргэдийн төлөөлөгчдийн

хурлын 2022 оны 13/49 дүгээр тогтоолоор анх 2,222,294.0 мянган төгрөгөөр баталсан байна. 2023.07.05-ны өдрийн хуралдааны 15/09 тоот тогтоолоор тодотгол хийж 2,578,353.7 мянган төгрөгөөр баталсан.

*Хүснэгт 13. Төсвийн төлөвлөлт* /мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Төсвийн төсөл | Анх батлагдсан төсөв | Зөрүү |
|---|---|---|---|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 357,338.7 | 189,398.7 | -167,940.00 |
| Засаг даргын Тамгын газар | 922,816.7 | 960,274.9 | 37,458.20 |
| Өлзийт сумын сургууль | 320,886.6 | 253,421.6 | -67,465.00 |
| Өлзийт сумын цэцэрлэг | 58,507.2 | 43,778.7 | -14,728.50 |
| Эрүүл мэндийн төв | 56,130.6 | 56,653.1 | 522.50 |
| Соёлын төв | 128,305.5 | 56,344.2 | -71,961.30 |
| СХСан | | 103,000.0 | 103,000.00 |
| ОНХСан | | 559422.8 | 559,422.80 |
| Нийт дүн | 1,843,985.30 | 2,222,294.00 | 378,308.70 |

*Эх сурвалж: Өлзийт сумын ИТХ-ын тогтоол*

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд 2022 оны 13/49 дүгээр тогтоолоор анх 2,222,294.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.05-ны өдрийн хуралдааны 15/09 тоот тогтоолоор 356,059.7 мянган төгрөгөөр өсгөж 2,578,353.7 мянган төгрөг болсон.

Нийт эх үүсвэрийн 254,560.6 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 700,579.3 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 544,410.9 мянган төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 125,200.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 953,602.9 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авсан санхүүгийн дэмжлэг 700,579.3 мянга, орон нутгийн орлогоос 629,526.4 мянга, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс 248,043.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 99,897.1 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 142,636.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 227,584.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 14. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл* /мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | Төвлөрүүлэлт |
|---|---|---|---|---|---|
| ЗДТГ | 1,214,916.40 | 1,048,063.40 | 166,853.00 | 86.3% | 173,375.10 |
| ИТХ | 209,049.60 | 187,938.30 | 21,111.30 | 89.9% | 21,111.30 |
| Соёлын төв | 56,344.20 | 40,394.50 | 15,949.70 | 71.7% | 15,949.70 |
| Хоршоо хөгжүүлэх сан | 110,000.00 | 16,100.00 | 93,900.00 | 14.6% | |
| Сургууль | 255,921.60 | 251,225.00 | 4,696.60 | 98.2% | 4,696.60 |
| Цэцэрлэг | 45,978.70 | 40,590.00 | 5,388.70 | 88.3% | 6,718.70 |
| ЭМТ | 60,353.10 | 54,619.60 | 5,733.50 | 90.5% | 5,733.50 |
| ОНХС | 625,790.10 | 478,549.10 | 147,241.00 | 76.5% | |
| **Нийт дүн** | **2,578,353.70** | **2,117,479.90** | **460,873.80** | **82.1%** | **227,584.90** |

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 82.1 хувьтай байгаа нь ЗДТГ-ын урсгал зардлыг 166,853.0 мянга, ИТХ-ын урсгал зардлыг 21,111.3 мянга, Соёлын төвийн байр ашиглалтын зардлыг 15,949.7 мянга, Хоршоо хөгжүүлэх

сангийн зээл олголтыг 93,900.0 мянган, ОНХС-ын зардлыг 147,241.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### *3.5.3 Нэмэлт төсөв*

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 9,988.4 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоор 13,290.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бараа үйлчилгээний зардалд 12,575.8 мянган төгрөгийг зарцуулж, 10,703.0 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 15. Нэмэлт санхүүжилтийн тайлан /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | ЗДТГ | ИТХ | Нийт |
|---|---|---|---|
| **Нийт нэмэлт санхүүжилтийн орлого** | | | |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,688.4 | 1,300.0 | 9,988.4 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 13,286.4 | 4.0 | 13,290.4 |
| **НИЙТ ЗАРЛАГА** | **21,974.8** | **1,304.0** | **23,278.8** |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 11,275.8 | 1,300.0 | 12,575.8 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - | - |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | - | - |
| **ТӨВЛӨРҮҮЛСЭН** | **12,575.8** | **-** | **12,575.8** |

*Эх сурвалж: Өлзийт сумын санхүүгийн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан*

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сумын засаг даргын нөөц санг 51,000.0 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 38,323.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллагын 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Азбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 6 бүлэг, 8 зорилго, 111 зорилттойгоор төлөвлөж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд хэрэгжилтийг 89.4 хувийн гүйцэтгэлтэй үнэлжээ.

### 3.5.5 Аудитын гол асуудал

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,578,353.7 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,117,479.9 мянган төгрөгийг зарцуулж, 82.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тус сум нь 15 нэр төрлийн орлогоор 544,410.9 мянган төгрөг төвлөрүүлэхээс 792,500. мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 145.6 хувьтай биелүүлсэн.

Сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Өлзийт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Өлзийт сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

*Хүснэгт №16. Төсвийн шууд захирагчийн аудитын дүн*

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэсэн | | | Үүнээс | | | |
| | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Бүгд | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| **ЗДТГ** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **ИТХурал** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **ОНХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **СХС** | 1 | 1 | | 1 | | | | | |
| **НИЙТ ДҮН** | **4** | **4** | | **4** | | | | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Нийт илэрсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн 700.0 мянган төгрөгийн зөрчил илэрчээ. Хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн*

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Залруулга | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн зөрчил** | | | | | | | | | | |
| **ЗДТГ** | 2 | 700.0 | | | 1 | 700.0 | 1 | 0 | | |
| **ИТХ** | | | | | | | | | | |
| ***СТА зөрчлийн дүн*** | ***2*** | ***700.0*** | | | ***1*** | ***700.0*** | ***1*** | ***0*** | | |
| **СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал** | | | | | | | | | | |
| ***Нийцлийн аудитын дүн*** | | | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

*Хүснэгт 18: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт*

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| **Харьяа төсвийн байгууллагуудын дүн** | | **700.0** | | | |
| **Засаг даргын тамгын газар** | | **700.0** | | | |
| **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** | | | | | |
| 1 | 2023 онд ЗДТГ эзэмшүүлэхээр захирамж гарсан 5 эзэмших эрх бүхий 579,771 м2 газрыг санхүүгийн тайланд бүртгэж аваагүй байна. | 0 | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | М.Зоригт Ч.Батдорж |
| 2 | Баацагаан сумд болсон Говийн сумдын ЗДТГазрын ажилчдын дунд зохион байгуулагдсан спортын олон төрөлт тэмцээний оролцооны төлбөрийг нэмэлт санхүүжилтийн данснаас иргэн Д.Анхтуяагийн дансанд шилжүүлсэн байна. Энэ нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дах заалтуудыг зөрчсөн байна. | 700.0 | Төлбөрийн акт | Дарга, нягтлан бодогч | М.Зоригт Ч.Батдорж |
| | Дүн | **700.0** | | | |

*Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл*

### 3.5.6 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 2,578,353.7 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 2,117,479.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

*Хүснэгт 15. Төсвийн гүйцэтгэлийн тайлан* */мянган төгрөгөөр/*

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага** | **1,214,916.40** | **1,048,063.40** | **166,853.00** | **86.3%** |
| | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 605,807.40 | 568,224.00 | 37,583.40 | **93.8%** |
| | 80106 Баг, хорооны ҮАЗардал | 122,831.10 | 116,027.50 | 6,803.60 | **94.5%** |
| | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 10,000.00 | 10,000.00 | 0 | **100.0%** |
| | 82201 Гэмт хэргээс урьдчилан сэргийл | 9,283.20 | 8,983.00 | 300.2 | **96.8%** |
| | 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 51,000.00 | 38,323.20 | 12,676.80 | **75.1%** |
| | 81701 Байгаль орчныг хамгаалах, нөхө | 396,494.70 | 290,701.50 | 105,793.20 | **73.3%** |
| | 82212 Хур хог хаягдал, орчны бохирдл | 13,500.00 | 13,113.10 | 386.9 | **97.1%** |
| | 82310 Гамшигаас сэргийлэх сургалт,су | 6,000.00 | 2,691.00 | 3,309.00 | **44.9%** |
| 2 | **70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага** | **209,049.60** | **187,938.30** | **21,111.30** | **89.9%** |
| | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 184,516.60 | 163,803.90 | 20,712.70 | **88.8%** |
| | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 2,200.00 | 2,200.00 | 0 | **100.0%** |
| | 80825 Багийн ИНХ-ын дарны урамшуулал | 22,333.00 | 21,934.40 | 398.6 | **98.2%** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | **Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт** | **625,790.10** | **478,549.10** | **147,241.00** | **76.5%** |
| | 80904 Нийгмийн зориулалттай барилга | 238,868.50 | 177,889.30 | 60,979.20 | **74.5%** |
| | 83401 ОНХС - Итгэлцүүрээр олгох | 194,337.00 | 187,820.10 | 6,516.90 | **96.6%** |
| | 83402 ОНХС - Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр | 69.8 | 69.8 | 0 | **100.0%** |
| | 83403 ОНХС - Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | 26,341.80 | 26,341.80 | 0 | **100.0%** |
| | 83405 ОНХС - Малын тоо толгойн албан татвар | 132,360.90 | 52,616.00 | 79,744.90 | **39.8%** |
| | 83406 ОНХС - Бусад | 33,812.10 | 33,812.10 | 0 | **100.0%** |
| 4 | **72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих** | **110,000.00** | **16,100.00** | **93,900.00** | **14.6%** |
| | 82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих | 110,000.00 | 16,100.00 | 93,900.00 | **14.6%** |
| 5 | **71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ** | **60,353.10** | **54,619.60** | **5,733.50** | **90.5%** |
| | 80112 Нийтлэг үйлчилгээ | 60,353.10 | 54,619.60 | 5,733.50 | **90.5%** |
| 6 | **71802 Ерөнхий боловсрол** | **255,921.60** | **251,225.00** | **4,696.60** | **98.2%** |
| | 80112 Нийтлэг үйлчилгээ | 255,921.60 | 251,225.00 | 4,696.60 | **98.2%** |
| 7 | **71801 Сургуулийн өмнөх боловсрол** | **45,978.70** | **40,590.00** | **5,388.70** | **88.3%** |
| | 80112 Нийтлэг үйлчилгээ | 45,978.70 | 40,590.00 | 5,388.70 | **88.3%** |
| 8 | **71702 Соёл урлаг** | **56,344.20** | **40,394.50** | **15,949.70** | **71.7%** |
| | 80112 Нийтлэг үйлчилгээ | 56,344.20 | 40,394.50 | 15,949.70 | **71.7%** |
| | **Нийт** | **2,578,353.70** | **2,117,479.90** | **460,873.80** | **82.1%** |

*Эх сурвалж: Өлзийт сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан*

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлзийт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Өлзийт аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн 207 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,727,673.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 27,276.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 19,093.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Өлзийт сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 700.0 төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон. Тогтмол зардлын батлагдсан төлөвлөгөөг 93%-ийн гүйцэтгэлтэйгээр зарцуулж 24,456.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

**4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.7.1 Завсрын аудитын талаар**

Тайлант хугацаанд завсрын аудит хийгээгүй болно.

**4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 173 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна. Хэрэгжилт дараах байдалтай байна.

Хэрэгжилт дараах байдалтай байна.

*Хүснэгт 16. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж* */ мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 1 | 0 | 1 | 0 | 0 | 0 | 100 |
| ***Нийт*** | ***1*** | **0** | ***1*** | **0** | **0** | **0** | **100** |

*Эх сурвалж: Шийдвэрийн хэрэгжилт*

## 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 61,391.5 мянган төгрөгийн 2 зөрчил[1] илэрсэнд алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

## 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 155,115.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн ч орлогын нэр төрлөөр авч үзвэл иргэний орлогын татвар хураамж 7,033.2 мянга, бууны татвар 3,150.0 мянга, газрын төлбөр 4,731.7 мянга, газрын дуудлага худалдааны орлого 4,281.2 мянга, үл хөдлөх эрхийн хураамжийн татвар 1,080.2 мянга, малын тоо толгойн албан татвар 37,355.2 мянга, ус рашаан ашигласны төлбөр 60.2 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 3,000.0 мянган төгрөгөөр тус тус батласан төлөвлөгөө биелээгүй бөгөөд нийт 8 нэр төрлийн татварын орлогын 60,691.5 мянган төгрөгөөр тасарсан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8[2], Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3[3] дахь заалт, мөн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөж, зарцуулах зөвлөмжийг хүргүүлэв.

2. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал

*Илрүүлэлт:* Өлзийт сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 700.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 700.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага өгсөн байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.
[2] Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ
[3] жинхэнэ хэрэгжилтийн

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2.10[4] дахь заалтыг зөрчсөн бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Харьяа төсөвт байгууллагуудын санхүү төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг дээшлүүлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Өлзийт сумын Засаг дарга | 2 | 61,391.5 | | | | | 2 | 61,391.5 | | | | |
| **Дүн** | **2** | **61,391.5** | | | | | **2** | **61,391.5** | | | | |

4 өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.